

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНААС 2009 ОНЫ 08 ДУГААР САРД
ХИЙСЭН ГОЛ АЖИЛ**

Нэг. Бодлого төлөвлөлтийн асуудлаар:

1. Улсын Их Хурал болон Байнгын хороодын хурлаар хэлэлцүүлсэн асуудал:

- УИХ-ын Байгаль орчин, Хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооноос 2009 оны хаврын чуулганы завсарлагааны хугацаанд хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан “Бэлчээрийн тухай”, “Бараа түүхий эдийн биржийн тухай” хуулийн төслүүдийг хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах талаар УИХ-ын холбогдох гишүүдтэй хамтран ажиллаж, “Бараа түүхий эдийн биржийн тухай” хуулийн үзэл баримтлалыг батлуулав.

2. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудал:

- Ургацын урьдчилсан балансыг нэгтгэж 08 сарын 26-ны Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэв. Урьдчилсан байдлаар 2009 онд 338.9 мянган тонн үр тариа, үүнээс 335,5 мянган тонн буудай, 150.5 мянган тонн төмс, 99.2 мянган тонн хүнсний ногоо буюу нэг га талбайгаас 13.5 цн үр тариа, 114.3 цн төмс, 152 цн хүнсний ногоо тус тус хураан авахаар тогтоогдоод байна.

3. Судалж, боловсруулсан асуудлын талаар:

- ХХААХҮ-ийн салбарын 2010-2012 оны төсвийн төслийг боловсруулж Сангийн яаманд хүргүүлэв.
- Эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөлд салбарын талаар тусгах саналыг боловсруулж Сангийн яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд хүргүүлэв.
- “Хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг батлуулахаар ХЗДХ-ийн Сайдад хүргүүлээд байна.
- “Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийг дэмжих” хөтөлбөрийн төсөл боловсруулав.
- “Чацаргана” хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэг хөтөлбөрийн төсөл боловсруулж байна.
- “Тамхины хяналтын арга хэмжээг салбар дундын хэмжээнд зохицуулах” техникийн ажлын хэсгийн хуралдааны шийдвэрийн дагуу “Дүнсэн тамхины стандартын төсөл боловсруулах” ажлын хэсгийг Эрүүл мэнд, ХХААХҮ-ийн Сайдын хамтарсан тушаал гаргахаар шийдвэрлэв.
- “Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тухай” хуулийн төсөлтэй танилцан санал боловсруулж ХЗДХЯ-нд хүргүүлэв.
- Бараа түүхий эдийн биржийн “Арилжааны журам” болон “Дотоод дүрэм”-ийг боловсрууллаа.
- Сүү хөтөлбөрийн хүрээнд зээл олгох сүү үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгчдийг сонгон шалгаруулах төсөлд нийт 29 аж ахуйн нэгж хамрагдаж шалгарсан 21 аж ахуйн нэгжид 450 сая төгрөгийн төслийн зээлийн дэмжлэг үзүүлэх тухай 2009 оны 08 сарын 06 -ны ХХААХҮ-ийн Сайдын 180 дугаар тушаал гарч, тус зээлийг Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар дамжуулан олгох ажил хийгдэж байна.
- Хоршооны тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийг ХЗДХЯ, СЯ, хоршоодын холбоодын төлөөллийг оролцуулан байгуулж, ажлын хэсгийн хуралдааныг 08 дугаар сарын 25-нд зохион байгуулж, хуулийн төслийг бэлтгэн Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хэлэлцүүлэг хийлээ.
- “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулав.
- “Ноос хөтөлбөр”-ийн шинэчилсэн төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанд оруулахад бэлэн болгоод байна.
- Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэлийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох, уялдуулсан систем”-ийн дагуу гаргах ажлын хэсгийг байгуулах тухай Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2009 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 186/194 тоот хамтарсан тушаалаар байгуулан холбогдох яамд, мэргэжлийн холбоодоос саналыг авч нэгтгэж байна.

- Аймаг, орон нутагт шинээр байгуулах үйлдвэрийн тэргүүлэх чиглэл, 5 жилийн төлөвлөгөөний төслийг боловруулан Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд хүргүүлэв.
- Импорт орлох үйлдвэрийн тоног төхөөрөмж дотооддоо үйлдвэрлэж буй аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлэх татварын хөнгөлөлтийн талаар санал боловсруулж байна.
- Жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг лизингээр олгох үйлчилгээг явуулахтай холбогдуулан Санхүүгийн түрээс /лизинг/- ийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, эрх зүйн хүрээнд үүсч болох асуудлуудыг судалж холбогдох тайлбарыг гаргаад байна.

Хоёр. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудлаар:

- Ховд аймагт яамны өдөрлөгийг 08 дугар сарын 26-29-ны өдрүүдэд төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа. Дээрхи арга хэмжээнд Ажлын хэсгийн ахлагч Дэд сайд Ж.Сауле тэргүүтэй яамны газар хэлтсийн дарга, мэргэжилтнүүд нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй оролцож яамны нэгдсэн бодлого болон харьяа газруудын холбогдох мэдээллүүдийг хийж, санал солилцлоо. Тус өдөрлөгийн арга хэмжээнд гадаад, дотоодын 600 гаруй зочид, төлөөлөгчид 6 аймгийн 27 сумын 271 аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид, малчид, тариаланчид оролцож 403,2 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн тавигдаж 145,1 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. Үзэсгэлэнд давхардсан тоогоор 15500 хүн оролцлоо. Шилмэл малын үзэсгэлэн худалдааг 5 төрөл дээр сонгон шалгаруулалт явуулж, 3 аймгийн 22 сумын 76 малчин өрхийн 132 шилмэл мал хамрагдлаа.
- "Бэлчээр хадлангийн талбайг хашиж, сайжруулах, тэжээлийн ургамал тариалах" төсөлд шалгарсан Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь, Говь-Алтай, Баянхонгор, Ховд, Увс, Төв, Баян-Өлгий зэрэг нийт 10 аймаг, 26 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ хийж 194,0 сая төгрөгийн дэмжлэгт хамруулав.
- "Бэлчээр хадлангийн гарц муу байгаа Өмнөговь, Дундговь, Баянхонгор, Говь-Алтай аймгуудыг хадлангийн гарц сайн байгаа аймгуудад хадлангийн талбай ашиглуулах болон байгалийн цогцолбор газар, хилийн зурвас газруудад хадлан бэлтгэх ажлыг зохион байгуулж байна. 08 дугаар сарын 25-ны байдлаар 169794.0 тн хадлан, 8739.9 тн гар тэжээл бэлтгээд байна.
- ХХААХҮ-ийн Сайдын 2009 оны 182 дугаар тушаалаар батлагдсан "Хадлан тэжээл – 2009" уралдааны болзлыг улсын хэмжээнд телевиз, радиогоор сурталчилах ажлыг зохион байгуулж байна. Аймгуудыг хоёр бүс болгон бүс тус бүрээс нэг аймаг, нэг сум, гурван малчин өрх, улсын хэмжээнд гурван аж ахуйн нэгж шалгаруулна.
- "Эрчимжсэн МАА-н хөгжлийг дэмжих "хөтөлбөрийн хүрээнд гадаад, дотоодын зах зээлээс сүү, махны өндөр ашиг шимтэй 215 толгой үржлийн өсвөр үхэр худалдан авах тендерт шалгарсан "Ган сумч" ХХК-тай симменталь үүлдрийн 145 толгой үнээг Хэнтий аймгийн Биндэр сумаас,"Өрнөх дэвжих" ХХК-тай хар тарлан үүлдрийн 70 толгой үнээг БНХАУ-аас тус тус нийлүүлэхээр гэрээ байгуулж 09 дүгээр сарын 15-20-ны дотор хүлээн авах бэлтгэлийг ханган ажиллаж байна.
- ХХААХҮ-ийн сайдын 160 дугаар тушаалаар 13 аймаг Улаанбаатар хотод 32 худгийг 320,0 сая төгрөгт багтаан барьж байгуулах ажлын гэрээг орон нутгийн тендерт шалгарсан аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулан, 30 хувийн урьдчилгаа санхүүжилт олгох ажлыг зохион байгуулав.
- Монгол Улсаас ОХУ-д 2009 ондоо багтан нийтдээ 700,0 мянган толгой үржлийн хонь, ямаа экспортлох ажлын хүрээнд үржлийн зориулалттай хонь, ямааг экспортлох боломжтой тооны дээд хязгаар, тэдгээрийг гаргах хилийн боомтуудыг гаргаж аймаг, орон нутагт хүргүүллээ. "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль"-ийн дагуу нэг аймгаас үржлийн хонь, ямаа экспортлох аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжтой 3-аас илүүгүй байгууллага, аж ахуйн нэгж иргэнийг сонгон 12 аймгийн 36 аж ахуйн нэгжид ТНБД-ын тушаалаар тусгай зөвшөөрөл олгохоор боллоо. Өнөөдрийн байдлаар найман аж ахуйн нэгж тусгай зөвшөөрлөө аваад байна. Сонгогдсон иргэн, аж ахуйн нэгжүүдтэй хамтран тухайн орон нутгаас экспортлох нэг хонины үнийн дунджийг 100,0 мянган төгрөг, нэг ямааны үнийн дунджийг 60,0 мянган төгрөгөөс багагүй байхаар гэрээ хэлэлцээрүүдийг хийлгүүлж байна. Өнөөдрийн байдлаар Алтанбулаг боомтоор 400 хонь гаргаад байна.
- Уринш боловсруулалтын тайлан мэдээг аймаг, сум, дүүргээс авч нэгтгэлээ. Уринш боловсруулалтын ажил 06 дугаар сарын 10 эхэлсэн бөгөөд 08 сарын 25-ны байдлаар 218 мянган га талбайд нэгдүгээр, 119.0 мянган га талбайд хоёрдугаар боловсруулалт хийгээд байна. Үүний 46.6 мянган га талбайг нь дэвшилтэт технолгиор боловсруулсан байна. Нийт боловсруулсан уринш 244.5 мянган га талбай.
- Үр тарианы агуулах, үтрэм, элеваторын тооллогын дүн мэдээг орон нутгаас авч нэгтгэн Сайдын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхэд бэлэн болгов. Тооллогоор тариалангийн бүс нутгийн 8 аймаг, 43 суманд 224 аж ахуйн нэгжийн 200 үтрэм, 118 үрийн агуулах, 22 элеватор хамрагдсан байна.

- Элеватор худалдан авах нээлттэй тендерийн үнэлгээг зохих тодруулгыг авч хийн Сангийн яаманд хянуулж байна.
- Ургац хураалтын техникийн бэлэн байдлын мэдээг орон нутгаас авч нэгтгэв. Техникийн засвар бэлэн байдал 85 хувьтай байна.
- Нийслэлийн Засаг даргатай байгуулсан санамж бичгийн дагуу нийслэлийн аж ахуйн нэгж, иргэдэд нийт 200 хүлэмж олгоод байна. БНСУ-ын Засгийн газраас олгосон Хүлэмжийн нээлтийн ажлыг зохион байгуулан оролцов.
- Улсын ургацын комиссын бүрэлдэхүүн, гишүүдийн ажиллах аймаг, сум, ажлын удирдамжийг Сайдын 198 дугаар тушаалаар батлуулж, анхын хурлыг 09 сарын 01-нд хуралдуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.
- “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийн Үндэсний зөвлөлийн анхдугаар хурлыг 8 дугаар сарын 17-нд зохион байгуулж, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, үндэсний зөвлөлийн гишүүдийн саналыг тусган төлөвлөгөөг батлуулахаар тогтов.
- “Намрын ногоон өдрүүд 2009”-ийг зохион байгуулах ажлын хэсэг 2 удаа хуралдаж, арга хэмжээг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан, нэгдсэн арга хэмжээний бэлтгэлийг хангаж байна.
- Арьс ширний үйлдвэрийн салбарт одоо мөрдөгдөж байгаа бүх стандартыг дахин хянаж, үнэлгээ хийж, шинэчлэх, шинээр боловсруулах ажлын хэсгийг Сайдын 2009 оны 8-р сарын 18-ны өдрийн 190 тоот тушаалаар батлуулан ажиллаж байна.
- Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төслийг боловсруулж, Монгол Улсын Тэргүүн шадар сайдын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар 2 удаа хэлэлцүүлээ. Ажлын хэсэг, холбогдох яамдаас ирүүлсэн саналыг тусган хөтөлбөрийн төслийг 2009 оны 8-р сарын 31-ний өдөр Төрийн бус байгууллага, үйлдвэрлэгч, хувийн хэвшлийн 60 гаруй төлөөлөл оролцсон хэлэлцүүлэгийг зохион байгуулж, танилцуулав.
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх дэд сангийн төсөл шалгаруулалт, зээл олголтын явц, үйл ажиллагаатай танилцаж, хяналт хийх ажлын хэсгүүд Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу орон нутагт 2009 оны 8-р сарын 10-наас 25-ны өдрүүдэд бүх аймагт ажиллаж үнэлгээ хийв. Санхүүжилттэй холбоотой мэдээллийг ЗГХЭГ-т хүрүүлэн, ТВ-5 телевизийн “Монгол улсаа хөгжүүлэе” нэвтрүүлгээр Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл болон жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийн талаарх мэдээллийг хийлээ.
- Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэдтэй хамтран Малын удмын сангийн үндэсний төвийн үйлдвэрлэлийн байранд Дорсет үүлдрийн 30, Алтанбулаг хэвшлийн 10, бүгд 40 эм хонинд ороо идэвхижүүлэгч ашиглан дээрх үүлдрийн хуцны үрээр зохиомол хээлтүүлэг хийж, 352 ширхэг эвсэл эс ялган авч хөлдөөж хадгаллаа. Дорсет, Алтанбулаг, Барга хуцнаас үр авч хадгалах бэлтгэл ажил хангагдаад байна.
- Иргэд аж ахуйн нэгжийн санал хүсэлтийг үндэслэн зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтыг Улаанбаатар хотын Налайх дүүрэгт 2009 оны 9 дүгээр сарын 7-ноос эхлэн бод, бог малд зохиомол хээлтүүлэг хийх техникч бэлтгэх сургалт зохион байгуулахаас гадна Налайх дүүрэгт байрлаж байгаа -3 жижиг мах комбинатыг түшиглэн дадлага хийхээр хөдөө орон нутагт мэдэгдэл хүргүүлээд байна.

4. Гурав. Гадаад хамтын ажиллагаа болон дотоод ажлын талаар

- Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведев 2009 оны 8 дугаар сард Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр ХХААХҮ-ийн салбарын чиглэлээр оросын талд тавих, хэлэлцэх асуудлын саналыг боловсруулж нэгтгэн ГХЯ-нд хүргүүлэв.
- БНСУ-ын КОЙКА байгууллагын Ерөнхийлөгч Пак Дэ Вон тэргүүтэй төлөөлөгчдийн 08 дугаар сарын 13-14-нд Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр ХХААХҮ-ийн Сайдтай хийх уулзалт болон Хүлэмж хүлээлцэх ёслолын ажиллагааг зохион байгуулав.
- Монгол Улс, Европын Холбооны харилцаа хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх зорилго бүхий Европын Холбоотой хамтран ажиллах хөтөлбөрт ХХААХҮ-ийн салбарын асуудлаар тусгуулах саналыг боловсруулан Сангийн яаманд хүргүүлээ.
- Бүгд Найрамдах Чех Улсын Ерөнхий сайд Ян Фишер 2009 оны 9 дүгээр сарын 2-4-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлал хийхтэй холбогдуулан яриа хэлэлцээний сэдэвт тус салбараас оруулах санал болон салбарт хэрэгжиж буй төслийн танилцуулга, саналыг хүргүүлэв.
- ХБНГУ-д 2010 оны 01 дүгээр сард зохион байгуулагдах “Ногоон долоо хоног” үзэсгэлэн яармагт Монголын аж ахуйн нэгжүүдийг оролцуулах тухай урилга, танилцуулгыг илгээв.

- ХХААХҮЯ, ЖАЙКА байгууллага хамтран хэрэгжүүлж буй “Мал аж ахуй газар тариалангийн хосолсон загвар аж ахуйг дэмжих төсөл”-ийн ээлжит төслийн багийн хурлыг зохион байгуулж оролцов.
- Хүнсний баталгаат байдал үндэсний хөтөлбөрийг танилцуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор энэ оны 10 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулах “Хандивлагчдын дээд хэмжээний зөвлөлдөх уулзалт-ын урилгыг хандивлагч улс орон, олон улсын байгууллагуудад хүргүүлээд байна.
- Дэд сайд Т.Золжаргал тэргүүтэй төлөөлөгчдийн 08 дугаар сарын 10-15-нд БНХАУ-д хийсэн айлчлалыг зохион байгуулав. Айлчлалын үеэр БНХАУ-ын албаны хүмүүстэй хийсэн уулзалтаар БНХАУ-ын Тянжин хотын Дунжаны гаалийн онцгой бүсээр дамжуулан Монгол улсаас мах, махан бүтээгдхүүн 3-дагч улсад экспортлох, БНХАУ-ын нутгаар дамжуулан өнгөрүүлэхтэй холбогдсон асуудал болон боомт хотод манай эзэмшил бүхий газарт хөлдөөх агуулах, боловсруулах цех түүнчлэн Монгол Улсад бөөний худалдааны бирж байгуулахад дэмжлэг хүсэх талаар ярилцав.
- “Монгол Улсаас БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан хонь, ямааны хөлдөөсөн мах экспортлох үеийн мал эмнэлэгийн хорио цээрийн шаардлагын талаарх Протокол”-ын төслийг боловсруулж, БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт хорио цээрийн Ерөнхий газраас санал авахаар хүргүүлээд байна.
- ОХУ-ын Хөдөө аж ахуйн сайд Е.Скрынникаас ирүүлсэн Монгол Улсаас ОХУ-д нийлүүлэх хэрэглээний мал, мах махан бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, Монголын газар нутаг дээрхи мал, ХАА-н амьтныг гоц халдварт өвчнөөс эрүүлжүүлэхэд чиглэгдсэн 10 заалт бүхий мэдээлэл хүссэн албан тоотын хариуг МЭҮГ-тай хамтран дэлгэрэнгүй боловсруулж Оросын талд хүргүүлэв.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ